

**Авлигаас урьдчилан  
сэргийлэхэд нутгийн  
өөрөө удирдах байгууллагын  
зорилт**

**Н.Болормаа . Нийслэлийн Иргэдийн  
Төлөөлөгчдийн Хурлын дарга**

Авлигын эсрэг тэмцэх, түүнийг бууруулах ажлыг орон нутагт тууштай зохион байгуулан амжилтад хүргэхэд нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага, иргэний нийгэм, иргэдийн идэвхтэй оролцоо, тэдний дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай юм. Дэлхий нийтээр хүлээн зөвшөөрсөн "Сайн төр бол авлигагүй төр" гэсэн үзэл санааны дагуу авлигын эсрэг тэмцлийг нутгийн өөрөө удирдах байгууллага өөрөөсөө эхлэх нь зарчим баримталж байна. Засаг захиргаа, нэяг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 8.2-д Нутгийн өөрөө удирдах ёс нь чөлөөт сонгуулиар сонгогдсон төлөөлөгчтэй, түүнд тайлагнадаг гүйцэтгэх байгууллагатай, тухайн нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн асуудлыг иргэдийн ашиг сонирхолд нийцүүлэн хуулийн хүрээнд бие даан шийдвэрлэх эрх зүйн бодит чадвар мөн.

Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны хүрээнд Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараахь зорилтуудыг тавьж байна.

1. Авлигын эсрэг хууль тогтоомжийг нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд иргэдэд өргөн сурталчлах ажилд ач холбогдол, дэмжлэг өгч, энэ талаархи мэдээллийг иргэд, байгууллага чөлөөтэй авах нөхцөлийг хангах;

2. Тодорхой чиглэлээр бодлого боловсруулах, шийдвэр гаргахын өмнө олон нийтийн анхаарал татаж байгаа мэдээллийг нээлттэй болгох, сонирхогч нийгмийн бүлгүүдэд өөрийн бодлого, байр суурийг танилцуулах, хяналтын тодорхой аргыг дэвшүүлэн хэрэгжүүлэх бололцоо олгох зорилгоор харилцан зөвлөлдөж ажиллах боломжийг бүрдүүлэх;

3. Төсвийн орлого, түүний зарцуулалт, гадаадын зээл, тусламж, түүний хуваарилалтыг олон нийтэд тухай бүр нь мэдээлж байх, ил тод байх тогтолцоог бүрдүүлэх;

4. Тухайн байгууллагын чиг үүргийн дагуу зөвшөөрөл, эрх олгох, бүртгэл хийх, хяналт тавих, сонгон шалгаруулалт явуулах зэрэг асуудлыг шийдвэрлэх журмыг хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол олон нийтэд ойлгомжтой, нээлттэй, ил тод байлгаж, түүнтэй танилцах боломжийг хангах;

5. Нутгийн өөрөө удирдах болон захиргааны байгууллагаас гаргасан шийдвэр иргэд болон бусад сонирхогч талуудад ойлгомжтой, нээлттэй байх, шуурхай хүрч байх нөхцөлийг бий болгох;

6. Иргэдийн өргөдөл, гомдол, хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх шат дамжлагыг цөөрүүлэх;

7. Авлигын шалтгаан нөхцөлийг илрүүлэн тогтоох, тэдгээрийг арилгах, авлигын үйлдлийг таслан зогсоох, үр дагаврыг нь арилгах талаар холбогдох байгууллагатай хамтран ажиллах;

8. Авлигатай тэмцэх зорилго бүхий төрийн бус байгууллага, иргэдийн сайн дурын хөдөлгөөнийг дэмжих.

9. Нутгийн захиргааны байгууллага нээлттэй, иргэдийн ашиг сонирхолд нийцсэн үйл ажиллагаа явуулж байгаа эсэхэд тавих хяналтад төрийн бус байгууллагын оролцоог нэмэгдүүлж, хамтран ажиллах, мэдээллийг харилцан солилцох, олон нийтэд мэдээллийг тогтмол хүргэж байх;

10. Авлигатай тэмцэх талаар сургалт, сурталчилгаа явуулах, хөрөнгө, орлогын мэдүүлгийг хуульд заасан хугацаанд үнэн зөв гаргуулах, бүртгэх, хянах, зөвлөгөө өгөх асуудлыг хариуцан зохицуулах үүрэг бүхий албан тушаалтныг Засаг даргын Тамгын газарт ажиллуулах, хурлын дэргэд хяналтын зөвлөл ажиллуулах;

Нутгийн өөрөө удирдах байгууллага бол иргэдийг төртэй холбох гүүр юм. Иргэдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах, төлөөлөх үүргийг хүлээж байдаг. Авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх талаар баримтлах чиглэл, үйл ажиллагааны төлөвлөгөөг Нутгийн өөрөө удирдах байгууллагаас хянаж батлах нь зүйтэй байна.

Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагаас авлигатай тэмцэх хөтөлбөр, үйл ажиллагааны төлөвлөгөөний хүрээнд дараахь арга хэмжээг авах шаардлагатай гэж үзэж байна.

### ***Нэг.Төрийн албыг боловсронгуй болгох чиглэлээр:***

1.1. Төрийн албан хаагчдыг сонгон шалгаруулж, томилохдоо ил тод, шударгаар өрсөлдүүлэх тогтолцоог боловсронгуй болгох;

-Энэ байдалд хурлаас тавих хяналтыг сайжруулах;

1.2. Нутгийн төр, захиргааны байгууллагын ажилд хүнд суртал, шат дамжлагыг багасгах, зөвшөөрлийн тогтолцоог боловсронгуй болгох;

-Хурлаас журам гаргаж зохицуулах;

1.3. Төрийн албан хаагчийн хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах, түүнд хяналт тавих механизмыг улам боловсронгуй болгох;

-Хурлын дэргэд хяналтын зөвлөл байгуулах;

1.4. Нутгийн төр, захиргааны байгууллага бүрт ёс зүйг сахиулах, авилгалаас урьдчилан сэргийлэх асуудлыг эрхлэх орон тооны бус зөвлөл байгуулж ажиллуулах;  
-Хурлын төлөөлөгчдөөс оролцсон Ёс зүйн хороо байгуулах;

1.5. Мэдээллийн орчин үеийн технологид суурилсан, үйл ажиллагаагаа олон нийтэд ил тод явуулах;  
-Хурал, Засаг даргын дэргэд вебсайт нээх “Цахим” хөтөлбөр хэрэгжүүлэх;

### ***Хоёр. Урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд:***

2.1. Нийгмийн дэг журам хангах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг жил бүр төлөвлөхдөө Авлигатай тэмцэх Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх асуудлыг бие даасан хэсэг болгон авч үзэж, нутаг дэвсгэрийн хэмжээнд тодорхой зорилт дэвшүүлэн ажиллах;  
-Нийгэм –Эдийн Засгийн зорилтод жил бүр тусгах;

2.2. Нутаг дэвсгэрийн хэмжээнд гарсан авлигатай холбоотой болон, хээл хахуулийн хэрэг, зөрчлийн шалтгаан, нөхцөлийг судлан, түүнийг арилгах арга хэмжээ авах;  
-Орон нутгийн төсөвт зардлыг суулгаж өгөх;

2.3. Нутаг дэвсгэрийн аж ахуйн нэгж, байгууллагад авлигыг төрүүлэгч буюу өдөөгч хүчин зүйл бий болгохгүй байхад байнга анхаарч, авлигатай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх талаар зохиож буй ажлын явцыг тогтмол шалган туслах;  
-Жил бүр шалгалтын үр нөлөөний талаар Хурал хэлэлцдэг болох;

2.4. Авлигатай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх ажилд иргэд, олон нийтийг өргөн оролцуулж, идэвх зүтгэлтэй ажиллаж буй төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийг урамшуулж байх;

-Ажлыг дүгнэх хэлбэрийг тодорхой болгох;

2.5. Хэвлэл, мэдээллийн байгууллага төрийн байгууллагаас мэдээлэл авах боломжийг нэмэгдүүлж, хэвлэл, мэдээлэлд үнэн зөв мэдээлэл өгдөг тогтолцоо бий болгох;

-Байгууллага бүр мэдээллийг нээлттэй болгож чадсан эсэхийг хянах, дүгнэх;

2.6. Авлигаас урьдчилан сэргийлэх зорилго бүхий төрийн бус байгууллага, сайн дурын хөдөлгөөнтэй хамтран ажиллах гэрээ байгуулж, жил бүр дүгнэж байх;

2.7. Авлигын чиглэлээр хандивлагч орон, олон улсын байгууллага, төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран аймаг, нийслэлийн хэмжээнд тодорхой асуудлаар төсөл хэрэгжүүлэх;

-Хөтөлбөр, төслийг санхүүжүүлэх эх үүсвэрийг жил бүр орон нутгийн төсөв хэлэлцэх үед тодорхойлох;

2.8. Авлигын асуудлаар нийслэл, дүүргийн хүрээнд иргэд, олон нийтийг хамарсан зөвлөлгөөн, семинар, сургалт зохион байгуулах, орон нутгийн төсвөөс зардлыг санхүүжүүлэх;

2.9. Авлигын асуудлаар олон нийтийн санал, хандлагыг хоёр жил тутам судлан дүгнэлт хийж байх журам тогтоох;

***Гурав. Эдийн засаг, төсөв санхүү, өмч хувьчлалын ажлын хүрээнд:***

3.1. Орон нутгаас олгох зөвшөөрөл, лицензийг аль болох цөөрүүлэх, тендер зарлах, шалгаруулах ажиллагааг ил тод нээлттэй болгох, төрийн өмч, төсвийн хөрөнгө, гадаадын зээл, тусламжийн ашиглалт зарцуулалтад тавих хяналтыг чангатгах;

3.2. Авлигын эсрэг арга хэмжээнд зарцуулах хөрөнгийг орон нутгийн төсөвт жил тутам хүрэлцэх хэмжээгээр тусган тухай бүр санхүүжүүлж байх.

3.3. Орон нутгийн өмчийн аж ахуй нэгжийг зохиомол нөхцөлөөр дампууруулсан тохиолдолд авлига үүссэн эсэхийг шалгаж байх;

3.4. Орон нутгийн өмчийг хувьчилж авах сонирхлоо илэрхийлсэн хуулийн этгээдийн хөрөнгийн баталгааг татварын болон банкны байгууллагаас гаргуулан авч, хууль ёсоор бүрдүүлсэн өмч хөрөнгө мөн эсэхийг тогтоосны дараа өмч хувьчлалын үйл ажиллагаанд оролцуулдаг журам тогтоох;

3.5. Өмч хувьчлалын үйл ажиллагаанд хэвлэл, мэдээллийн оролцоог нэмэгдүүлж, хяналт шалгалтын дүн, шийдвэрийн талаар нийтэд байнга мэдээлж байх;

3.6. Өмч хувьчлалыг ил тод, олон нийтийн хяналтын дор явуулах;

3.7. Орон нутгийн өмчийн эзэмшил, хувьчлалтай холбоотой асуудлаар эрх мэдэл бүхий албан тушаалтан төрийн өмчийн объектыг хуулиас гадуур өрсөлдөөнгүйгээр хувьчилсан бол авлига үүссэн эсэхийг шалгаж байх;

3.8. Төсвийн төслийг боловсруулах, хэлэлцэх, батлах, зарцуулах үйл ажиллагаа ил тод, олон нийтийн хяналттай байх, төсвийн зарцуулалтын тайланд хяналт тавих механизм бүрдүүлэх;

Цаашид төрийн байгууллага, газар хэлтэс, удирдах болон гүйцэтгэх ажилтнууд иргэдэд чирэгдэлгүй, хөнгөн шуурхай шан харамж хэрэглэлгүй төрийн үйлчилгээг үзүүлдэг байх уур амьсгал бүрдүүлэхийн тулд нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагаас жил бүр тухайн байгууллага, албан тушаалтанд тодорхой чиглэл, даалгавар өгч, түүний хэрэгжилтийг иргэдээс санал авч, дүгнэн хэлэлцдэг журамд шилжих шаардлагатай гэж үзэж байна. Одоо мөрдөгдөж буй хууль тогтоомж, Авлигатай тэмцэх хөтөлбөрийн хүрээнд нутгийн өөрөө удирдах байгууллагаас авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэхийн тулд хэрэгжүүлэх ажлын зорилт, үйл ажиллагааны чиглэлийн талаар санал бодлоо илэрхийллээ. Цаашид авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг хариуцаж зохицуулах, хяналт тавих үүрэгтэй орон нутгийн зөвлөлийг байгуулах талаар Та бүхнийг оновчтой санал дэвшүүлнэ гэдэгт иргэж байна.

“Авлигагүй нийгэм-Тогтвортой хөгжлийн гарц” Үндэсний бага хурлаас гарах зөвлөлийн төслийг дэмжиж байна.

Энэхүү зөвлөмжийн хүрээнд Авлигаас урьдчилан сэргийлэх, авлигатай тэмцэх ажлыг эрчимжүүлэх ажлыг цаг хугацаа алдалгүй шуурхай зохион байгуулахыг нутгийн өөрөө удирдах байгууллага, захиргааны байгууллагад хандаж уриалж байна.



Анхаарал тавьсанд баярлалаа.

